



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам

Малын тэжээлийн зах зээлийн судалгаа

Герман-Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл

Гэрээт судлаач Б.Эрдэнэболор

2017 он

Гарчиг

1-р бүлэг. Судалгааны үндэслэл, арга зүй

2-р бүлэг. Тэжээлийн зах зээлийн гадаад орчин, тэжээл
үйлдвэрлэлийн талаар төрөөс баримталж буй бодлого

3-р бүлэг. Тэжээлийн нийлүүлэлт

4-р бүлэг. Тэжээлийн хэрэглээ

5-р бүлэг. Тэжээлийн хэрэглээг нэмэгдүүлэх потенциал

(6-р бүлэг. Шүүн хэлэлцэхүй: Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг
нэмэгдүүлэх боломж, шийдвэрлэх асуудлууд)

7-р бүлэг. Дүгнэлт, зөвлөмж

1-р бүлэг. Судалгааны үндэслэл, арга зүй

Судалгааны үндэслэл

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүн экспортлох бодлогын зорилтуудыг шийдвэрлэхэд малын тэжээлийн хангамжийг сайжруулах асуудал чухал байр суурь эзэлдэг.
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малын тэжээллэгийг сайжруулах зорилтууд “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (2015-2025), “Монгол мал” хөтөлбөр (2010-2021) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан. Уг зорилтуудын дагуу дотоодын тэжээл үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц арга хэмжээ МУ-ын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан байна.
- Герман-Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл Монгол улсад тогтвортой ХАА-н үйлдвэрлэлийг дэмжихэд бодлогын зөвлөгөө өгөх чиг үүргийнхээ хүрээнд энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгааны зорилго, зорилт, хязгаарлалт

Зорилго:

- Тэжээлийн зах зээлийн оролцогч талуудад зах зээлийн өнөөгийн байдал, боломж, чиг хандлагын талаар бодит мэдээлэл өгөх, бодлогын орчныг сайжруулах.

Зорилтууд

- Малын тэжээлийн зах зээлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, дүгнэх
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийн зах зээлийн потенциалыг тодорхойлох
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж, тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох
- Уг боломж, бэрхшээлүүд төрөөс тэжээл үйлдвэрлэлийн талаар баримталж буй бодлогод хэрхэн тусгагдсан болохыг тодорхойлж дүгнэх
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийн бодлогын орчныг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулах

Хязгаарлалт: Энэхүү судалгаа нь бодлогын зөвлөмж гаргах зорилтынхоо дагуу зах зээлийн тогтолцооны дүн шинжилгээнд түлхүү төвлөрч хийгдсэн тул маркетингийн судалгааны нарийвчилсан арга зүйг ашиглаагүй.

Судалгааны арга зүй

- Судалгааг 2017 оны 5-р сараас 10-р сарын хооронд гүйцэтгэсэн. Тоон ба чанарын судалгааны арга зүйг хослуулан ашигласан.
- Тоон судалгааны хүрээнд статистик ба бусад тоон мэдээллийн боловсруулалт ба дараахь загвар тооцоонууд гүйцэтгэсэн.
 - Эрчимжсэн (ба хагас эрчимжсэн) маллагаатай сүүний үхэр, махны үхэр, гахай, тахианы сүргийн бүтцийг тодорхойлох;
 - Эрчимжсэн мал ахуйн фермүүдийн тэжээлийн хэрэглээг хэрэгцээнд нь харьцуулж, солилцлын энергийн нэгжээр баланслах
- Чанарын судалгааны арга болох ярилцлагад Тэжээлийн зах зээлийн оролцогч талуудаас төлөөлүүлж Улаанбаатар хот, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Увс аймгуудаас 88 хүнийг түүвэрлэн хамруулсан. Судалгааг биечлэн буюу утас, имэйлээр авсан.
- Ашигласан материал: статистик мэдээ, судалгааны тайлан, илтгэлүүд, ХХААХҮЯ-ны тайлан, презентаци, судалгаа, хууль дүрэм, бодлогы баримт бичгүүд, бусад материал.

**2-р бүлэг. Тэжээлийн зах
зээлийн гадаад орчин,
тэжээл үйлдвэрлэлийн
талаар төрөөс баримталж
буй бодлого**

Мал аж ахуй нь эдийн засгийн тулгуур салбар эзэлдэг боловч бүтээмж, өрсөлдөх чадвар бага.

- МАА-н салбар нь 2016 оны байдлаар ДНБ-ий 10%, ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн 84%, экспортын орлогын 6.6%, хөдөөгийн нийт өрхийн 56%-ийн амьжиргааны гол эх үүсвэрийг бүрдүүлж байна.
- МАА-н салбар 2016 онд 400 мянган тонн мах, 891.5 сая литр сүү, 27.4 мянган тонн хонины ноос, 9.4 мянган тонн ноолуур, 1.7 мянган тонн тэмээний ноос, 14 сая ширхэг арьс шир үйлдвэрлэсэн бөгөөд МАА-н нийт үйлдвэрлэл 3.5 их наяд төгрөгт хүрчээ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зонхилох аргачлал нь бэлчээрийн маллагаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 71%-ийг мал бэлчээх зориулалтаар, үнэгүй ашиглаж байна.
- Бэлчээрийн малын ашиг шим бага, тэжээл ба бусад орцын хэрэглээ минималь. Тэжээлийг малчид зөвхөн малын хорогдлоос сэргийлэх зорилгоор ашиглаж байна.

Малын тоо толгой 61.5 саяд хүрсэн бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

- 2016 оны эцэст малын нийт тоо толгой 61.5 сая хүрсэн бөгөөд нийт малын 87%-ийг бог, 13%-ийг бод эзэлж байна.

| Малын төрөл | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|-----------------|--------|--------|--------|--------|--------|
| Хонь | 18,141 | 20,066 | 23,215 | 24,943 | 27,857 |
| Ямаа | 17,559 | 19,228 | 22,009 | 23,593 | 25,575 |
| Үхэр | 2,585 | 2,910 | 3,414 | 3,780 | 4,081 |
| Адуу | 2,330 | 2,619 | 2,996 | 3,295 | 3,636 |
| Тэмээ | 306 | 322 | 349 | 368 | 401 |
| Нийт тоо толгой | 40,921 | 45,144 | 51,983 | 55,980 | 61,549 |

Малчин өрхийн талаас илүү хувь нь амиа аргацаах төвшинд МАА-н үйлдвэрлэл эрхэлдэг.

- Нийт 160,650 малчин өрхийн 43% нь 200 хүртэл, 35% нь 201-500, 43% нь 500-аас дээш тооны малтай.

| Малчин өрх | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|-----------------------------|---------|---------|---------|---------|---------|
| Нийт тоо | 146,081 | 145,311 | 149,735 | 153,085 | 160,650 |
| Үүнд: | | | | | |
| 100 хүртэл малтай | 44,953 | 40,976 | 36,393 | 35,246 | 36,336 |
| 101-200 малтай | 38,262 | 35,705 | 34,906 | 34,315 | 33,519 |
| 201-500 малтай | 45,682 | 47,467 | 51,580 | 53,218 | 55,575 |
| 501-999 малтай | 13,669 | 16,372 | 20,190 | 22,034 | 25,459 |
| 1000-1499 малтай | 2,950 | 3,983 | 5,505 | 6,827 | 7,989 |
| 1500-2000 малтай | 370 | 555 | 802 | 970 | 1,177 |
| 2000-аас дээш малтай | 195 | 253 | 359 | 475 | 595 |

Малын тооны өсөлтийг хязгаарлаж, чанарын өсөлтийг хангах төрийн бодлого дутагдаж байна.

- Мал хувьчлагдаж, нэгдэл, сангийн аж ахуйнуудыг тарааснаас хойш мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний тогтолцоог сэргээн хөгжүүлж чадаагүй өдий хүрчээ. Малчдын монгол үнээ 250 кг амьдын жинтэй, 500 литр саамтай байхад фермерийн аж ахуйд маллаж буй эрлийз үнээ 450 кг амьдын жин, 2500 литр саамтай байна.
- Бэлчээрийг малчид үнэгүй ашигладаг байдал нь 1990 оноос хойш малын тоо толгой 238%-иар өсөх боломжийг бүрдүүлсэн. Нийт бэлчээрийн 65-аас доошгүй хувьд ургамлын төрөл зүйл ба ургац буурсан байна.
- Бэлчээрийн малын тооны өсөлтийг хязгаарлах, чанарын өсөлтийг хангах чиглэлээр дорвитой арга хэмжээг өнгөрсөн 27 жилд төрөөс аваагүй байна. 2012-2016 оны Засгийн газруудын үед малын хөлийн татвар авах санаачлага гарсан боловч энэ нь орон нутгийн бие дааж шийдвэрлэх асуудал болж хувираад яваандаа замхарсан.

Эрчимжсэн мал аж ахуйн ферм, тэдгээрийн малын тоо толгой (ХХААХҮЯ, 2017).

| Ферм, аж ахуйн тоо | Фермийн аж ахуйн тоо | Малын тоо толгой | Нэг фермд ногдох малын тоо |
|----------------------|----------------------|------------------|----------------------------|
| Саалийн ферм | 1,472 | 60,998 | 41 |
| Махны үхрийн аж ахуй | 175 | 14,974 | 86 |
| Сүүний ямааны ферм | 47 | 1,219 | 26 |
| Гахайн ферм (ААН) | 70 | 17,723 | 253 |
| Гахайн ферм (өрх) | 980 | 17,981 | 18 |
| Тахианы ферм (ААН) | 40 | 841,005 | 21,025 |
| Тахианы ферм (өрх) | 1,269 | 39,109 | 31 |

Эрчимжсэн мал аж ахуй

- Мал аж ахуйн фермүүдийн байршлын мэдээ 2016, 2017 онд гараагүй. Хамгийн сүүлийн буюу 2015 оны ҮСГ-ын мэдээнээс үзвэл гол төвлөрөл нь Улаанбаатар хот орчмын бүс нутагт байна. Түүнчлэн Төв, Сэлэнгэ, Хэнтий, Булган, Өвөрхангай аймгуудад хамгийн олон тооны ферм бүртгэгдсэн байна. Махны үхрийн тоогоор мөн Сүхбаатар ба Орхон аймгууд 3 ба 5-р байр эзэлсэн байдаг (2015).
- Саалийн үхрийн эрчимжсэн аж ахуй нь 2000 он хүртэл голчлон өрхийн жижиг, дунд бизнесийн хэлбэрээр хөгжсөн бол 2000-аад оны сүүлээс 300-600 үхэртэй томоохон механикжсан фермүүд байгуулагдаж эхэлсэн. 100-аас дээш үхэртэй фермүүд ихэвчлэн тэжээлийн ургамлын тариаланг хавсран эрхэлдэг.
- Нийт 30 орчим мянган саалийн үнээний 80% нь өрхийн жижиг, дунд фермүүдэд, үлдэх 20% нь, үүнд цэвэр үүлдрийн үхрийн 90 орчим хувийг томоохон аж ахуйн нэгжүүдэд маллаж байна.

Эрчимжсэн мал аж ахуй

- Мал аж ахуйн фермүүдийн байршлын мэдээ 2016, 2017 онд гараагүй. Хамгийн сүүлийн буюу 2015 оны ҮСГ-ын мэдээнээс үзвэл гол төвлөрөл нь Улаанбаатар хот орчмын бүс нутагт байна. Түүнчлэн Төв, Сэлэнгэ, Хэнтий, Булган, Өвөрхангай аймгуудад хамгийн олон тооны ферм бүртгэгдсэн байна. Махны үхрийн тоогоор мөн Сүхбаатар ба Орхон аймгууд 3 ба 5-р байр эзэлсэн байдаг (2015).
- Саалийн үхрийн эрчимжсэн аж ахуй нь 2000 он хүртэл голчлон өрхийн жижиг, дунд бизнесийн хэлбэрээр хөгжсөн бол 2000-аад оны сүүлээс 300-600 үхэртэй томоохон механикжсан фермүүд байгуулагдаж эхэлсэн. Одоогоор нийт 30 орчим мянган саалийн үнээний 80% нь өрхийн жижиг, дунд фермүүдэд, үлдэх 20% нь, үүнд нийт 7500 цэвэр үүлдрийн үнээний 90 орчим хувийг томоохон аж ахуйн нэгжүүдэд маллаж байна.
- Өрхийн саалийн ферм дунджаар 15-20 үнээтэй. Ихэнхи өрхийн фермүүдэд тэжээлийн ургамал тариалах газар, тоног төхөөрөмж байхгүй. Тэжээлийн ургамлын тариаланг голчлон 100-аас дээш үхэртэй фермүүд хавсран эрхэлдэг.
- ХХААХҮЯ-ны мэдээгээр цэвэр үүлдрийн үнээний саамын дундаж гарц хоногт 18 литр, эрлийз үнээнийх 8 литр байна.

Эрчимжсэн мал аж ахуй

- Махны үхрийн аж ахуйг бэлчээрийн маллагаанд тулгуурласан байдлаар эрхэлж байна. Мөн нэг эзний үхрийг хэд хэдэн аж ахуйд хувааж маллах, түүнчлэн зөвхөн өсвөр үхэр бордох байдлаар ажилладаг махны үхрийн аж ахуйнууд бий. Бэлчээрийн мал аж ахуйгаас ялгагдах онцлог нь үхэр нь цэвэр, эрлийз дангаар буюу монгол үхэртэй холимог бөгөөд нэмэлт тэжээлийг тогтмол хэрэглэдэг. Махны үхрийн аж ахуйнууд өөртөө тэжээл бэлтгэх нь ховор. Зөвхөн газар тариалан хавсран эрхэлдэг Гацуурт зэрэг томоохон аж ахуйнууд тэжээлээ өөрөө бэлтгэдэг.

Гахай, тахианы аж ахуйн хувьд 200-аас доош гахайтай буюу 1000-аас доош тахиатай фермүүд голчлон гар ажиллагаатай. Цөөн тооны механикжсан томоохон фермүүд тэжээлийн ургамлын тариалан, тэжээл үйлдвэрлэл хавсран эрхэлж байна.



Тэжээлийн төрлүүд

1. Байгалиас бэлтгэж буй тэжээл

- Хадлан өвс
- Гар тэжээл
- Хужир, шүү

2. Газар тариалангаас бэлтгэж буй тэжээл

- Ногоон тэжээл
- Сүрэл
- Үр тариа, хүнсний ногооны хаягдал
- Дарш


3. Үйлдвэрийн аргаар бэлтгэж буй тэжээл

- Хивэг
- Хорголжин тэжээл
- Багсармал хүчит тэжээл/ Бүрэн найрлагат хүчит тэжээл

Тэжээлийн ургамлын тариалан 2016: нийт тариалангийн газрын 6% нийт ургацын 7%.

| Тэжээлийн ургамал | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|-----------------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Тариалсан газар, га | | | | | |
| Ногоон тэжээлийн ургамал | 9,424 | 10,500 | 9,023 | 11,244 | 19,311 |
| Олон наст | 2,860 | 2,364 | 3,789 | 4,377 | 3,986 |
| Даршны ургамал | 1,196 | 1,348 | 2,965 | 4,648 | 256 |
| Бусад | 303 | 144 | 1,200 | 3,572 | 6,341 |
| Нийт тариалсан газар | 13,784 | 14,390 | 16,976 | 23,841 | 29,893 |
| Ургац, тонн | | | | | |
| Ногоон тэжээлийн ургамал | 30,077 | 29,697 | 24,547 | 38,468 | 34,393 |
| Олон наст | 9,964 | 8,038 | 7,963 | 8,850 | 11,263 |
| Даршны ургамал | 6,178 | 3,879 | 9,236 | 1,344 | 2,222 |
| Бусад | 0.5 | 1,024 | 2,533 | 519 | 5,546 |
| Нийт ургац | 46,219 | 42,638 | 44,278 | 49,181 | 53,424 |

Тэжээлийн ургамал 1000-аас дээш га-д тариалсан аймгууд (2016)



Дорнод 7452 га, Төв 5626 га, Сэлэнгэ 5458 га, Сүхбаатар 2020 га, Увс 1980 га, Архангай 1442 га

Тэжээлийн ургамлын тариалан

Ургамлын төрөл зүйл:

- **Ногоон тэжээлийн ургамлууд:** ихэвчлэн овъёос, мөн арвай, хөх тариа, судан өвс, эдгээрийн холимог
- **Тэжээлийн олон наст:** ихэвчлэн царгас, мөн согоовор ба хошоонгор
- **Даршны ургамал:** эрдэнэ шиш, наранцэцэг
- **Бусад тэжээлийн ургамал:** вандуй, шар буурцаг, рапс ба гич


Тариалангийн байршил, хэмжээ (2016):

- **Ногоон тэжээлийн ургамлууд:** Дархан-Уул аймгаас бусад 20 аймагт, мөн Улаанбаатарт, 4-5533 га-д
- **Тэжээлийн олон наст:** 14 аймагт, 0.1-1671 га-д.
- **Даршны ургамал:** 8 аймагт, 0.3-214 га-д.
- **Бусад тэжээлийн ургамал:** 7 аймаг ба Улаанбаатар хотод, 2-4320 га-д.

Сэлэнгэ, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн олон төрөл зүйлийн тэжээлийн ургамал тариалдаг. Эдгээр 3 байршилд нийт ногоон тэжээлийн 50%, даршны ургамлын 90%-ийг бэлтгэж байна.

Тэжээл үйлдвэрлэгчдийн тоо (ХХААХҮЯ, 2017)

| № | Аймаг | Тэжээлийн үйлдвэр, цех | | |
|----|------------|------------------------|----------------|-----------------------|
| | | Нийт | Ажиллаж байгаа | Үйл ажиллагаа зогссон |
| 1 | Архангай | 3 | 2 | 1 |
| 2 | Баян-Өлгий | 3 | 0 | 3 |
| 3 | Говь-Алтай | 1 | 1 | 0 |
| 4 | Дорноговь | 4 | 3 | 1 |
| 5 | Дорнод | 2 | 1 | 1 |
| 6 | Дундговь | 2 | 1 | 1 |
| 7 | Завхан | 1 | 1 | 0 |
| 8 | Орхон | 8 | 7 | 1 |
| 9 | Өвөрхангай | 28 | 9 | 19 |
| 10 | Өмнөговь | 3 | 0 | 3 |
| 11 | Сүхбаатар | 2 | 0 | 2 |
| 12 | Сэлэнгэ | 7 | 6 | 1 |
| 13 | Хэнтий | 11 | 6 | 5 |
| 14 | Увс | 5 | 5 | 0 |
| 15 | Хөвсгөл | 10 | 9 | 1 |
| 16 | Улаанбаата | 5 | 4 | 2 |
| 17 | Булган | 10 | 6 | 4 |
| 18 | Төв | 8 | 5 | 3 |
| 19 | Ховд | 3 | 2 | 1 |
| 20 | Баянхонгор | 0 | 0 | 0 |
| 21 | Говьсүмбэр | 0 | 0 | 0 |
| 22 | Дархан-Уул | 0 | 0 | 0 |
| | Нийт | 116 | 68 | 49 |



ХХААХҮЯ-нд 18 аймаг, Улаанбаатар хотын нийт 116 тэжээл үйлдвэрлэгч бүртгэгдсэн ба эдгээрийн нийт хүчин чадал жилд 374 мянган тонн.

| Үйлдвэрлэгчийн төрөл | Тоо | Бүтээгдэхүүн | Үйлдвэрлэлийн нийлбэр хүчин чадал, тонн/жил |
|--|------------|---|--|
| Тэжээлийн үйлдвэр, цехүүд | 11 | Хивэг, хорголжин тэжээл, холимог тэжээл, хүчит ба уурагт тэжээл | 175 мянган тонн |
| Тэжээл холигч бүхий урилын үйлдвэр | 5 | Хивэг, холимог тэжээл | 7 мянган тонн |
| Гурилын үйлдвэр | 34 | Хивэг | 106 мянган тонн |
| Хорголжин тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж бүхий бага оврын тээрэм | 2 | Хивэг, хорголжин тэжээл | 1.5 мянган тонн |
| Хорголжин тэжээл үйлдвэрлэгч | 5 | Хорголжин тэжээл | 7.5 мянган тонн |
| Үр тарианы бутлуур | 7 | Будааны няцалбар | 17 мянган тонн |
| Тэжээл холигч | 41 | Холимог тэжээл | 60 мянган тонн |
| Бусад | 11 | Ногоон тэжээл, өвс, эрдэс тэжээл | N/A |

ХХААХҮЯ-нд бүртгэгдсэн 116 тэжээл үйлдвэрлэгчээс одоо ажиллаж буй, хүчин чадал нь тодорхой үйлдвэрлэгч 62, эдгээрийн нийлбэр хүчин чадал жилд 338 мянган тонн.

| Үйлдвэрлэгчийн төрөл | Тоо | Бүтээгдэхүүн | Үйлдвэрлэлийн нийлбэр хүчин чадал, тонн/жил |
|---|-----|---|---|
| Тэжээлийн үйлдвэр, цехүүд | 11 | Хивэг, хорголжин тэжээл, холимог тэжээл, хүчит ба уурагт тэжээл | 172 мянган тонн |
| Тэжээл холигч бүхий урилын үйлдвэр | 4 | Хивэг, холимог тэжээл | 3.7 мянган тонн |
| Гурилын үйлдвэр | 26 | Хивэг | 87 мянган тонн |
| Хорголжин тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж бүхий бага оврын тээрэм | 2 | Хивэг, хорголжин тэжээл | 1.5 мянган тонн |
| Хорголжин тэжээл үйлдвэрлэгч | 2 | Хорголжин тэжээл | 2.9 мянган тонн |
| Үр тарианы бутлуур | 5 | Будааны няцалбар | 11.5 мянган тонн |
| Тэжээл холигч | 16 | Холимог тэжээл | 60 мянган тонн |
| Бусад | 3 | Ногоон тэжээл, өвс, эрдэс тэжээл | N/A |

ХХААХҮЯ-нд бүртгэгдсэн 116 тэжээл үйлдвэрлэгчээс одоо ажиллаж буй, хүчин чадал нь тодорхой үйлдвэрлэгч 62, эдгээрийн нийлбэр хүчин чадал жилд 338 мянган тонн.

- Энэхүү 62 үйлдвэрлэгчийн 20 нь бага оврын хорголжин тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж, үр тарианы бутлуур, тэжээл холигч ажиллуулдаг малчид, фермер, малчдын хоршоод учраас тэдгээрийг тэжээлийн үйлдвэр буюу цех гэж тооцоход төвөгтэй.
- Тэжээлийн үйлдвэр, цехэд тооцогдох 42 үйлдвэрлэгчийн нийлбэр хүчин чадал нь жилд 266 мянган тонн.
- Гүрбазар ба бусад (2017), Тогтохбаяр ба бусад (2017) нарын баримжаалснаар тэжээлийн үйлдвэр, цехүүд нийт хүчин чадлынхаа 20-30 хувиар ажиллаж байна.
- Өөрийнхөө эрчимжсэн мал аж ахуйд тэжээл нийлүүлдэг Оргио (Ажигана ХХК), Хишигтэн нүүдэлчин, Агро фийд (Түмэн шувуут) зэрэг үйлдвэрлэгчид 40-90 хүртэл хувийг ашиглаж буй. Нийт тэжээлийн үйлдвэр, цехүүдийн дунджаар авч үзвэл Монгол улс үйлдвэрийн тэжээл бэлтгэх хүчин чадлынхаа 38 орчим хувийг ашиглаж байна.

11 тэжээлийн үйлдвэрийн нийт хүчин чадал жилд 172 мянган тонн, үүний 38%-ийг ашиглаж байна.

| Нэр | Байршил | Бүтээгдэхүүн | Малын төрөл | Хүчин чадал, 1000 тонн/жил |
|---------------------|---------|-----------------------------------|----------------------|-------------------------------|
| Алтан тариа | УБ | Хивэг, хорголжин, бүрэн найрлагат | Хивэгч, гахай, тахиа | 43.8 |
| Агро фийд | УБ | Хорголжин, бүрэн найрлагат | Тахиа, адуу | 36.5 |
| Баялаг эмээлт | УБ | Хорголжин, бүрэн найрлагат | Тахиа, адуу | 14.6 |
| Нүүдэл тэжээл | УБ | Хивэг, хорголжин, бүрэн найрлагат | Хивэгч, адуу | 9.6 |
| Оргио | УБ | Хорголжин, бүрэн найрлагат | Тахиа | 5.0 |
| Майнд теч – УБ | УБ | Уурагт хүчит тэжээл | Хивэгч, гахай, тахиа | 7.3 |
| Хишигтэн нүүдэлчин | Төв | Хорголжин, бүрэн найрлагат | Хивэгч, адуу | 5.5 |
| Алтан шиш | Төв | Хорголжин, бүрэн найрлагат | Гахай, хивэгч | 14.6 |
| Майнд теч – Сэлэнгэ | Сэлэнгэ | Уурагт хүчит тэжээл | Хивэгч, гахай, тахиа | 23.7 |
| Уранцацал | Сэлэнгэ | Хорголжин | Хивэгч, адуу | 7.3 |
| Алтай групп | Дорнод | Хорголжин | Хивэгч, адуу | 4.5 |
| Нийт | | | | 172.4 |

Тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 хувийг импортоор хангаж байна.

- Түмэн шувуут 100 га-д, Хишигтэн Нүүдэлчин 600 га-д тэжээлийн ургамал тариалдаг. Майнд Теч Сэлэнгийн тариаланчдад рапсын үр өгч тариалуулаад ургацыг нь эргүүлэн авч ашигладаг. Бусад тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдээ худалдаж авдаг.
- Импортоор авдаг гол түүхий эд: эрдэнэ шиш, шар буурцаг, рапс ба шар буурцагийн шахдас, премикс, амин хүчил.

Тэжээл үйлдвэрлэлийн талаар төрөөс баримталж буй бодлого: Бодлогын зорилтууд

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /2015-2025/:

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд тэжээлийн ургамал тариалах газар олгох,
- Тэжээл үйлдвэрлэлийн нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх,
- Тариалангийн сэлгээнд тэжээлийн ургамал багтаах
- Эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх
- Уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамлын төрөл, сортуудыг нутагшуулах, үрийн нөөц бүрдүүлэх

ТХХААТББ-ыг үр дүнг хэмжих тоон үзүүлэлтүүдэд тэжээлтэй холбоотой нэг үзүүлэлт багтсан :

- Нийт тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэлийн эзлэх хувь 2014 онд 0.7 байсныг 2025 онд 10 хувьд хүргэж нэмэгдүүлэх.

Тэжээл үйлдвэрлэлийн талаар төрөөс баримталж буй бодлого: Бодлогын зорилтууд

“Монгол мал” хөтөлбөр /2015-2025/:

- Бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Бага оврын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Тэжээлийн ургамлын тариалан, газар тариалангийн бүтээгдэхүүний хаягдлыг малын тэжээлд ашиглахыг нэмэгдүүлэх,
- Өвс, тэжээлийн чанарыг алдагдуулахгүй хадгалах технологи нэвтрүүлэх,
- Орон нутагт өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэх,
- Говийн бүсийн малчдад хадлангийн техник ба Хангайн бүсэд хадлан хадах газар ашиглуулах.

ММХ-ийн үр дүнг хэмжих тоон үзүүлэлтүүдэд тэжээлтэй холбоотой дараахь үзүүлэлтүүд багтсан:

- Аймаг, сумдын өвс, тэжээлийн фонд, тэжээлийн үйлдвэр, цехийн тоог 2008 онд 38 байсныг 2015 онд 150 хүргэх.
- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг 2008 онд 560.5 мянган тонн Тэжээлийн Нэгж (ТН) байсныг 2021 онд 900 мянган тоннд хүргэх.
- Нийт тэжээлийн хангамжид үйлдвэрийн тэжээлийн эзлэх хувь 2008 онд 9.6% байсныг 2021 онд 40% хүргэх

Тэжээл үйлдвэрлэлийн талаар төрөөс баримталж буй бодлого: Бодлогын дэмжлэг (2012-2016 онд)

ХХААХҮЯ-наас хадлан, тэжээлийн тоног төхөөрөмж хөнгөлөлттэй үнээр олгосон:

- Хадлангийн ба бага оврын тэжээл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцлөөр малчид, фермерүүдэд олгоход 7.6 тэрбум төгрөг зарцуулсан.
- Хадлангийн тоног төхөөрөмж 2017 оны байдлаар: 7101 трактор, 8394 тракторын буюу морин хадуур, 558 хаман боогч.

Төрөөс эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, мал зээлээр олгоход нийт 71 тэрбум төгрөг дараахь эх үүсвэрүүдээс зарцуулсан.

- Хөгжлийн банк/ Чингис бонд (2013): 13.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 7 саалийн фермд,
- “Гол нэрийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр (2013): 38.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 14 махны үхрийн аж ахуй, 4 гахайн ферм, 2 тахианы ферм, 3 хонины эрчимжсэн аж ахуй, 1 холимог мал аж ахуйн фермд,
- “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөр” (2012-2015): 10.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд (тоо нь тодорхойгүй),
- ХХААХҮЯ-ны төсөв (2012-2016): 8.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 554 ферм, мөн 443.4 сая төгрөгийн үнэ бүхий цэвэр үүлдрийн малыг 317 фермд зээлээр тус тус олгосон.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Дотоодын тэжээл үйлдвэрлэл, тэжээлийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 72.3 тэрбум төгрөгийн төсөв бүхий 13 ажил төлөвлөгдсөн. Эдгээр ажлууд нь дараахь зорилтуудад чиглэнэ.

- Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгуудад шинэ тэжээлийн үйлдвэрүүд байгуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Тэжээлийн ургамлын шинэ сортуудын үр үржүүлэх, тариаланчдад бордоо, ургамал хамгааллын бодис хөнгөлөлттэй үнээр олгох, үр тарианы сэлгээнд тэжээлийн ургамал багтаах замаар тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх,
- Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэх,
- Хадлангийн ба бага оврын тэжээл бэлтгэх тоног төхөөрөмжийг малчид, фермерүүдэд хөнгөлөлттэй нөхцлөөр олгох,
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд тариалангийн газар олгох,
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох.

| Төлөвлөсөн ажлууд | Шалгуур үзүүлэлт | Төсөв, сая төгрөг |
|--|--|----------------------|
| Тэжээл үйлдвэрлэлд шууд нөлөөлөх ажлууд | | |
| Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгуудад тэжээлийн үйлдвэр байгуулах, Тэжээлийн ургамлын үр үржүүлгийг дэмжих. | Бүсийн 4 үйлдвэр шинээр байгуулагдана, Тэжээлийн ургамлын үрийн шинэчлэлт хийгдэж тариалалт нэмэгдэнэ. | 20,000 |
| Шууд бусаар нөлөөлөх МАА-н салбарын ажлууд | | |
| Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх, Өвс, тэжээлийн агуулах нэмж байгуулах. | Өвс, тэжээлийн 20 агуулах нэмж баригдана. | 5,500 |
| Эрчимжсэн мал аж ахуй, өвс тэжээл бэлтгэлийн технологийг шинэчилж, техникийн лизингийн үйлчилгээ нэвтрүүлнэ. | МАА-н үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн 20%-ийг шинэчилж, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэлтийг 15% хүргэнэ. | 3,200 |
| Өндөр ашигт шимт үүлдрийн махны үхрийн аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ. | 40-өөс цөөнгүй махны үхрийн аж ахуйд дэмжлэг үзүүлнэ. | 4,000 |
| Хот орчмын сүү, махны үхрийн фермүүдэд зээлийн дэмжлэг үзүүлнэ. | 40-өөс цөөнгүй сүү, махны үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоно. | 1,200 |
| Гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд зээлийн дэмжлэг үзүүлнэ. | 20-иос цөөнгүй гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд хөнгөлөлттэй зээл олгоно. | 600 |
| Бэлчээрийн маллагаагаар үхэр, хонины мах үйлдвэрлэх, төл мал бордоход дэмжлэг үзүүлнэ. | Заасан чиглэлээр 20-ос цөөнгүй аж ахуйд дэмжлэг үзүүлнэ. | 4,000 |
| Шууд бусаар нөлөөлөх ГТ-ийн салбарын ажлууд | | |
| Тариаланчдад бордоо, ургамал хамгааллын бодис хөнгөлөлттэй үнээр олгоно. | Бордоо, ургамал хамгааллын бодис хөнгөлөлттэй үнээр олгоно. | 14,680 |
| Сэлгээнд шинэ таримлууд тариална. | Нийт тариалсан газрын 20%-ийг сэлгээний таримлууд эзэлнэ. | 2,000 |
| Төвийн бүсэд тариалангийн газрын ашиглалтыг сайжруулж, бусад бүсүүдэд атаршсан газрыг ашиглалтад оруулна. | Тариалангийн газар Төвийн бүсэд 600 мянган га, Баруун бүсэд 70 - мянган га, Зүүн бүсэд 190 мянган га, Хангайн бүсэд 100 мянган га-д хүрнэ. | |
| Ганд тэсвэртэй, өндөр ургацтай үр тариа, тосны ургамал, тэжээлийн ургамлын сорт нутагшуулж, үрийг нь үржүүлнэ. | Таримал ургамлын 9 шинэ сорт, үүнд тэжээлийн ургамлын 5 сортыг нутагшуулж, үрийг нь үржүүлнэ. | 2,300 |
| Шууд ба шууд бусаар нөлөөлөх бусад ажлууд | | |
| ТХХААТББ ба “Монгол мал” хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлнэ. | ТХХААТББ ба ММХ-ийн биелэлтийг 80%-д хүргэнэ. | 14,000 |
| Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих шинэ хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих шинэ хөтөлбөрийг 2017 онд боловсруулж, 2020 он дуустал хэрэгжүүлнэ. | 800 |

3-р бүлэг.

Тэжээлийн нийлүүлэлт

Тэжээл үйлдвэрлэл 2012-2016 онд

- Сүүлийн 5 жилд дотоодын тэжээл бэлтгэл жилд 1.3-1.5 сая тонн байгаагийн 75-80%-ийг хадлан бэлтгэл, 10-13%-ийг гар тэжээл ба хужир, шүү бэлтгэл эзэлж байна.
- Байгалиас бэлтгэсэн дээрх тэжээлээс бусад тэжээлийн үйлдвэрлэл жилд 186 дунджаар 186 тонн, үүний 38%-ийг бүдүүн ба шүүст тэжээл, 62%-ийг хүчит тэжээл эзэлж байна.

| Тэжээл, 1000 тонн | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|--|--------|--------|------------|------------|---------|
| Хадлан өвс ¹ | 1182.7 | 1122.5 | 1221.2 | 1014.5 | 1100 |
| Сүрэл ¹ | 39.2 | 21.7 | 22.7 | 44.7 | 35.7 |
| Ногоон тэжээл ² | 30.1 | 29.7 | 24.5 | 38.5 | 34.4 |
| Дарш ¹ | | | 3.5 | 3.1 | 7.9 |
| Хаягдал төмс, хүнсний ногоо ³ | N/A | N/A | 2.5 to 3.5 | 2.5 to 3.5 | 2.5-3.5 |
| Гар тэжээл ¹ | 56.9 | 45.9 | 37.4 | 42.5 | 38.1 |
| Хужир, шүү ¹ | 113.6 | 143.5 | 117.6 | 124.1 | 105.6 |
| Үр тарианы хаягдал ² | 14.4 | 10 | 6.8 | 6.1 | 7.2 |
| Хивэг ⁴ | | | | 70-80 | 70-80 |
| Үйлдвэрийн тэжээл | 41.9 | 40.7 | 29.6 | 25 | 27.1 |

Эх сурвалж: 1-ХХААХҮЯ, 2-ҮСГ, 3-Зохиогчийн тооцоолсоноор, 4-ХХААХҮЯ-ны тооцоолсоноор

Тэжээлийн импорт 2015-2016

- Тэжээл ба тэжээлийн орцын нийт импорт: 2015 онд 69 мянган тонн, 2016 онд 43 мянган тонн.
- Импортоор орж ирсэн тэжээлийн орц: эрдэнэ шиш, арвай, шар буурцаг, ясны гурил, үр тарианы хаягдал, цардуулын ба архи, пивоны үйлдвэрлийн хаягдал, шар буурцаг боловсруулах үйлдвэрийн хаягдал, бусад хүнсний үйлдвэрийн хаягдал.
- Түүнчлэн импортлосон үр тарианы хаягдлын 50 орчим хувийг тэжээл үйлдвэрлэлд, үлдэх 50 хувийг малын тэжээлд шууд ашигласан.
- Малын тэжээлд шууд ашиглагдсан импортын тэжээлийн хэмжээ 2015 онд 30 мянган тонн, 2016 онд 18.6 мянган тонн.

| Тэжээл, тонн | 2015 | 2016 |
|------------------------|----------|----------|
| Өвс | - | 20.0 |
| Овьёос (ногоон тэжээл) | 9,288.8 | 10,913.1 |
| Үр тарианы хаягдал | 18,316.3 | 5,892.6 |
| Холимог хүчит тэжээл | 2,438.5 | 1,814.8 |
| Нийт | 30,043.7 | 18,640.5 |


Гүрбазар /2017/-ын тооцоолсоноор импортын хүчит тэжээлийн 95%-ийг шувууны аж ахуйд хэрэглэдэг. Мөн тэжээлийг голчлон Хятад, ОХУ, АНУ-гаас импортлодог байна.

Тэжээлийн зах зээл ба борлуулалтын нийт үнэлгээ


- 2016 онд нийлүүлэгдсэн нийт тэжээлийг хэрэглэгчийн үнээр тооцвол нийт 321 тэрбум төгрөг, үүний 97% хувь буюу 311.5 тэрбум төгрөг дотоодод бэлтгэсэн тэжээлд ногдоно. Импортын тэжээлийн нийт үнэ 9.5 тэрбум төгрөг.
- Зах зээлд борлуулагдсан тэжээлийн нийт үнэлгээ 188 тэрбум төгрөг. Үлдэх 133 тэрбум төгрөгийн тэжээлийг малчид, тариаланчид, фермерүүд өөрсдийн хэрэгцээндээ бэлтгэсэн байна.

Тэжээлийн нийт зах зээл 321 тэрбум төгрөг: Зах зээлийн бүтэц

Тэжээлийн төрлөөр




Борлуулалтын хувь хэмжээгээр




- Тэжээлийн зах зээлийн 80%-ийг байгалиас бэлтгэж буй тэжээл болох өвс, хужир шүү эзэлж байна.
- Бүдүүн ба шүүст тэжээлийн 2%, хүчит тэжээлийн 8%-ийг импортоор авч байна.
- Бүдүүн ба шүүст тэжээлийн 50 орчим хувь, хужир шүүний 90 орчим хувийг малчид, фермерүүд өөрсдийн хэрэгцээнд бэлтгэдэг. Харин хүчит тэжээлийн 99%-ийг зах зээлээс худалдан авдаг.

Дотоодын тэжээл нийлүүлэлт 311 тэрбум төгрөг

Тэжээлийн төрлөөр



Хүчит тэжээлийн бүтэц



- Дотоодод бэлтгэсэн бүдүүн ба шүүст тэжээлийн нийт үнэлгээ 235 тэрбум төгрөг (үүнд өвс 220 тэрбум төгрөг), хүчит тэжээлийн үнэлгээ 61 тэрбум төгрөг. Хужир шүүний үнэлгээ 16 тэрбум төгрөг.
- Хүчит тэжээлийн зах зээлийн 46%-ийг үр тарианы хаягдал ба хивэг, 54%-ийг үйлдвэрийн тэжээл эзэлж байна.

4-р бүлэг.

Тэжээлийн хэрэглээ

Тэжээлийн хэрэглээ: Бэлчээрийн мал аж ахуй

- Малчид орлогын төвшнөөсөө хамааран нийт орлогынхоо 5-20 хувийг мал аж ахуйдаа зарцуулдаг. Мал аж ахуйд зарцуулсан мөнгөний 30 орчим хувийг хадлан бэлтгэх, өвс, тэжээл худалдан авахад зарцуулдаг.
- Нийт малчид 2016 онд жилд 142.2 тэрбум орчим төгрөг тэжээлд зарцуулсаны 90 орчим хувь нь хадлан бэлтгэл ба өвс худалдан авахад, 8% нь хивэг авахад, 1% нь ногоон тэжээл авахад, үлдэх 1% нь гар тэжээл, хужир шүү бэлтгэхэд зарцуулагдсан.

| Үзүүлэлт | Малчин өрхүүдийн малын тооны бүлэглэл | | | | |
|--|---------------------------------------|-----------|------------|------------|---------------|
| | 100 хүртэл | 101-200 | 201-500 | 501-999 | 1000-аас дээш |
| Малчин өрхийн тоо | 36,336 | 33,519 | 55,575 | 25,459 | 9,761 |
| Жилийн орлого, төгрөг | 6,949,526 | 9,525,501 | 14,724,929 | 28,514,546 | 53,659,107 |
| Нэг өрхийн тэжээлд зарцуулах төсөв, төгрөг | 104,243 | 428,648 | 883,496 | 1,710,873 | 3,219,546 |
| Нийт өрхүүдийн тэжээлд зарцуулах төсөв, сая төгрөг | 3,788 | 14,368 | 49,100 | 43,557 | 31,426 |
| Нийт малчдын тэжээлд зарцуулах төсөв, сая төгрөг | | | 142,239 | | |

Тэжээлийн хэрэглээ: Бэлчээрийн мал аж ахуй

Малчдын 2016 онд өөрсдөө бэлтгэж буюу худалдан авч хэрэглэсэн тэжээл:

- 995.7 мянган тонн өвс
- 20.7 мянган тонн хивэг
- 5.7 мянган тонн ногоон тэжээл
- Нийт гар тэжээлийн 100%, хужир шүүний 90 орчим хувь

Үүн дээр нэмж аймаг, сумдын аюулгүйн нөөцөөс малчдад 20.4 мянган тонн өвс, 4.6 мянган тонн хивэг олгосон байна.

Ийнхүү малчдын тэжээлийн нийт хэрэглээ нь 2016 онд:

- 1 сая тонн өвс,
- 25 мянган тонн хивэг
- 5.7 мянган тонн ногоон тэжээл
- 38 мянган тонн гар тэжээл
- 95 мянган тонн хужир, шүү байв.

Тэжээлийн хэрэглээ: Эрчимжсэн мал аж ахуй

Эрчимжсэн мал аж ахуйд 2016 онд хэрэглэсэн тэжээл:

- 170.2 мянган тонн бүдүүн ба шүүст тэжээл
- 76.7 мянган тонн хүчит тэжээл
- 10.6 мянган тонн хужир, шүү

Нийт эрчимжсэн мал аж ахуйн фермүүдийн бүдүүн ба шүүст тэжээлийн хэрэглээний 9%, хүчит тэжээлийн хэрэглээний 3% нь сүүний ямаа, хурдан морины аж ахуйнуудад ногдоно. Иймд судалгааны фокус нь тэжээлийн хэрэглээний 90 гаруй хувийг эзлэх сүү, махны үхэр, гахай, тахианы аж ахуйнуудад чиглэсэн болно.

Бидний тооцоолсоноор сүү, махны үхэр, гахай, тахианы фермүүд 2016 онд нийт 154 мянган тонн бүдүүн ба шүүст тэжээл, 74 мянган тонн хүчит тэжээл хэрэглэсэн байна.

Малчдын 2016 онд хэрэглэсэн нийт тэжээлийн мөнгөн үнэлгээ нь 232.8 тэрбум төгрөг байсан бол эрчимжсэн МАА-н тэжээлийн хэрэглээ нь 88.1 тэрбум төгрөг байв. Эрчимжсэн фермүүдийг дотор нь задалж үзвэл тэжээлийн хэрэглээний 58% нь сүү, махны үхрийн фермүүд, 10% нь гахайн фермүүд, 27% нь тахианы фермүүдэд тус тус ногдож байна.

Сүү, махны үхрийн фермүүд 2016 онд нийт 49.9 тэрбум төгрөг, гахайн фермүүд 8.8 тэрбум төгрөг, тахианы фермүүд 23.4 тэрбум төгрөг тэжээлд зарцуулжээ.


| Тэжээл | Нийлүүлэлт, тонн | Малчдын хэрэглээ, тонн | Эрчимжсэн мал аж ахуйн фермүүдийн хэрэглээ, тонн | | | | |
|------------------------------|---------------------|---------------------------|--|-------------------|--------------------|------------------|-----------------|
| | | | Сүү, махны үхрийн ферм | Гахайн фермүүд | Тахианы фермүүд | Бусад фермүүд | Фермүүд нийт |
| Бүдүүн ба шүүс тэжээл | | | | | | | |
| Өвс, дотоод | 1,100,000 | 1,016,073 | 75,534 | | | 8,393 | 83,927 |
| Өвс, импорт | 20 | | 18 | | | 2 | 20 |
| Сүрэл, дотоод | 35,700 | | 32,130 | | | 3,570 | 35,700 |
| Ногоон тэжээл, дотоод | 34,400 | 5,690 | 25,839 | | | 2,871 | 28,710 |
| Овьёос, импорт | 10,913 | | 9,822 | | | 1,091 | 10,913 |
| Дарш, дотоод | 7,900 | | 7,900 | | | 0 | 7,900 |
| Хаягдал төмс, ногоо | 3,000 | | | 3,000 | | 0 | 3,000 |
| Бүдүүн ба шүүст нийт | 1,191,933 | 1,021,762 | 151,244 | 3,000 | - | 15,927 | 170,171 |
| Хүчит тэжээл | | | | | | | |
| Үр тарианы хаягдал, дотоод | 7,200 | | 1,440 | 1,080 | 4,320 | 360 | 7,200 |
| Үр тарианы хаягдал, импорт | 5,893 | | 295 | 884 | 4,714 | - | 5,893 |
| Хивэг, дотоод | 60,000 | 25,289 | 29,504 | 3,471 | 0 | 1,736 | 34,711 |
| Холимог хүчит тэжээл, дотоод | 27,100 | | 2,981 | 6,504 | 17,344 | 271 | 27,100 |
| Холимог хүчит тэжээл, импорт | 1,815 | | 18 | 54 | 1,724 | 18 | 1,815 |
| Хүчит тэжээл нийт | 102,007 | 25,289 | 34,238 | 11,993 | 28,102 | 2,385 | 76,718 |
| Бусад | | | | | | | |
| Гар тэжээл | 38,100 | 38,100 | | | | | |
| Хужир, шүү | 105,600 | 95,040 | | | | | 10,560 |
| Бусад нийт | 143,700 | 133,140 | | | | | 10,560 |
| Нийт | 1,437,641 | 1,180,192 | 185,481 | 14,993 | 28,102 | 18,312 | 257,449 |

| Fodder | Нийт хэрэглээ, сая төгрөг | Малчдын хэрэглээ, сая төгрөг | Эрчимжсэн мал аж ахуйн фермүүдийн хэрэглээ, сая төгрөг | | | | | |
|-------------------------------|---------------------------|------------------------------|--|----------------|-----------------|---------------|-----------------|--------------|
| | | | Сүү, махны үхрийн ферм | Гахайн фермүүд | Тахианы фермүүд | Бусад фермүүд | Фермүүд нийт | |
| Бүдүүн ба шүүст тэжээл | | | | | | | | |
| Өвс, дотоод | 220,000 | 203,215 | 15,107 | | | | 1,679 | 16,785 |
| Өвс, импорт | 1,902 | | 2 | | | | 0 | 2 |
| Сүрэл, дотоод | 3,570 | | 3,213 | | | | 357 | 3,570 |
| Ногоон тэжээл | 8,600 | 1,422 | 6,460 | | | | 718 | 7,178 |
| Овьёос, импорт | 4,469 | | 4,022 | | | | 447 | 4,469 |
| Дарш, дотоод | 1,975 | | 1,975 | | | | 0 | 1,975 |
| Хаягдал төмс, ногоо | 600 | | | | 600 | | 0 | 600 |
| Бүдүүн ба шүүст нийт | 239,216 | 204,637 | 30,778 | 600 | - | 3,200 | 34,579 | |
| Хүчит тэжээл | | | | | | | | |
| Үр тарианы хаягдал, дотоод | 2,160 | | 504 | 378 | 1,512 | | 126 | 2,520 |
| Үр тарианы хаягдал, импорт | 1,703 | | 85 | 255 | 1,362 | | | 1,703 |
| Хивэг, дотоод | 33,000 | 13,909 | 16,227 | 1,909 | | | 955 | 19,091 |
| Холимог хүчит тэжээл, дотоод | 25,352 | | 2,236 | 5,528 | 17,344 | | 244 | 25,352 |
| Холимог хүчит тэжээл, импорт | 3,320 | | 33 | 100 | 3,154 | | 33 | 3,320 |
| Хүчит тэжээл нийт | 65,534 | 13,909 | 19,085 | 8,170 | 23,372 | 1,358 | 51,985 | |
| Бусад | | | | | | | | |
| Гар тэжээл | | | | | | | | |
| Хужир, шүү | 15,840 | 14,256 | | | | | | 1,584 |
| Бусад нийт | 15,840 | 14,256 | | | | | | 1,584 |
| Нийт | 322,238 | 232,802 | 49,864 | 8,770 | 23,372 | 4,558 | 4288,148 | |


Үйлдвэрийн тэжээлийн нийт хэрэглээ

- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хивэг, хүчит тэжээлийн нийт хэрэглээ 2016 онд 61.7 тэрбум төгрөг, үүний 23% нь малчдад, 77% нь эрчимжсэн мал аж ахуйд ногдоно. Хамгийн том хэрэглэгчид болох тахианы фермүүд 20.5 тэрбум төгрөг зарцуулж, зах зээлийн 33%-ийг эзэлсэн байна. Сүү, махны үхрийн фермүүд 18.5 тэрбум төгрөг, гахайн фермүүд 7.5 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

Хивэгийн хэрэглээ 2016 онд нийт 33 тэрбум төгрөг



Холимог хүчит тэжээлийн хэрэглээ 2016 онд нийт 28.7 тэрбум төгрөг



5-р бүлэг.
Тэжээлийн хэрэглээг
нэмэгдүүлэх потенциал

Эрчимжсэн МАА-н тэжээлийн баланс: Нийт баланс (солилцын энергиэр)

| Үзүүлэлт | Сүү, махны үхрийн фермүүд | Гахайн фермүүд | Тахианы фермүүд | Нийт фермүүд |
|---|---------------------------------|---------------------|---------------------|----------------------|
| Тэжээлийн хэрэглээ, MJ ME | | | | |
| Дотоодын нийлүүлэлтээс | 876,069,350 | 148,463,097 | 215,635,679 | 1,240,168,126 |
| Импортын тэжээлээс | 21,971,071 | 8,162,749 | 50,570,502 | 80,704,321 |
| Нийт хэрэглээ | 898,040,420 | 156,625,846 | 266,206,181 | 1,320,872,447 |
| Нийт тэжээлийн хэрэгцээ, MJ ME | 1,259,154,699 | 293,102,032 | 390,847,355 | 1,943,104,087 |
| Тэжээлийн баланс нийт хэрэглээнд харьцуулснаар, MJ ME | -361,114,279 | -136,476,187 | -124,641,174 | -622,231,640 |
| Нийт тэжээлийн хангамжийн хувь | 71% | 53% | 68% | 68% |
| Тэжээлийн баланс дотоодод үйлдвэрлэсэн тэжээлийн хэрэглээнд харьцуулснаар, MJ ME | -383,085,349 | -144,638,935 | -175,211,677 | -702,935,961 |
| Дотоодын тэжээлийн хангамжийн хувь | 70% | 51% | 55% | 64% |

Эрчимжсэн МАА-н тэжээлийн баланс: Бүдүүн ба шүүст тэжээлийн баланс (солилцын энергиэр)

| Үзүүлэлт | Сүү, махны үхрийн фермүүд | Гахайн фермүүд | Нийт |
|--|---------------------------|----------------|--------------|
| Бүдүүн ба шүүст тэжээлийн хэрэглээ, MJ ME | | | |
| Нийт хэрэглээ | 605,209,398 | 31,008,000 | 636,217,398 |
| Дотоодын нийлүүлэлтээс | 585,915,935 | 31,008,000 | 616,923,935 |
| Бүдүүн ба шүүст тэжээлийн хэрэгцээ, MJ ME | | | |
| Нийт хэрэглээнд харьцуулсан энергийн баланс, MJ ME | 670,456,708 | 47,723,919 | 718,180,627 |
| Нийт хангамжийн хувь, % | 90% | 65% | 89% |
| Дотоодод үйлдвэрлэсэн тэжээлийн хэрэглээнд харьцуулсан энергийн баланс, MJ ME | | | |
| Дотоодын хангамжийн хувь, % | -84,540,774 | -16,715,919 | -101,256,692 |
| Дотоодын хангамжийн хувь, % | 87% | 65% | 86% |

Эрчимжсэн МАА-н тэжээлийн баланс: Хүчит тэжээлийн баланс (солилцын энергиэр)

| Үзүүлэлт | Сүү, махны үхрийн фермүүд | Гахайн фермүүд | Тахианы фермүүд | Нийт |
|--|---------------------------------|-------------------|--------------------|---------------|
| Хүчит тэжээлийн хэрэглээ, MJ ME | | | | |
| Нийт хэрэглээ | 292,831,022 | 125,617,846 | 266,206,181 | 684,655,049 |
| Дотоодын нийлүүлэлтээс | 290,153,415 | 177,455,097 | 215,635,679 | 623,244,191 |
| Хүчит тэжээлийн хэрэгцээ, MJ ME | | | | |
| Нийт хэрэглээнд харьцуулсан энергийн баланс, MJ ME | 588,697,990 | 245,378,114 | 390,847,355 | 1,224,923,460 |
| Нийт хангамжийн хувь, % | 50% | 51% | 68% | 56% |
| Дотоодын үйлдвэрлэсэн тэжээлийн хэрэглээнд харьцуулсан энергийн баланс, MJ ME | | | | |
| Дотоодын хангамжийн хувь, % | -298,544,575 | -127,923,017 | -175,211,677 | -601,679,269 |
| Дотоодын хангамжийн хувь, % | 49% | 48% | 55% | 51% |

Бэлчээрийн МАА-д

1-р сценари: Фермүүдийн тэжээлийн хэрэглээний бүтэц өөрчлөгдөхгүй, хэмжээ нь хэрэгцээг нь хангах хэмжээнд хүрнэ.

2-р сценари: Фермүүдийн тэжээлийн хэрэглээний бүтэц бага зэрэг сайжран өөрчлөгдөх ба нийт хангамж нь хэрэгцээг нь хангах хэмжээнд хүрнэ.

Эдгээр 2 сценариар загварчилсан тооцоо хийж үзэхэд дараахь дүгнэлт гарсан болно.

- **Бүдүүн ба шүүст тэжээлийн хэрэглээ нэмэгдэх потенциал:** Нийт хэрэгцээ 172-186 мянган тонн орчим. 2016 оны хангамжийн төвшинд харьцуулахад нэмж шаардагдах хэмжээ нь 28-41 мянган тонн. Үүнд өвс 8.1 мянган тонн хүртэл, дарш 7.9 мянган тонн хүртэл, ногоон тэжээл 14-29 мянган тонн хүртэл, хаягдал төмс, хүнсний ногоо 1617 тонн хүртэл
- **Хүчит тэжээлийн хэрэглээ нэмэгдэх потенциал:** Нийт хэрэгцээ 131-133.5 мянган тонн. Нэмж шаардагдах хэмжээ 64-67 мянган тонн. Үүнд үр тарианы хаягдал 14-21 мянган тонн, вандуй, шар буурцаг, рапс зэрэг уурагт тэжээлийн ургамал 3.4 мянган тонн хүртэл, хивэг 13-33 мянган тонн, холимог хүчит тэжээл 20-27 мянган тонн.
- **Нэмж шаардагдах тэжээлийн мөнгөн үнэлгээ:** 1-р сценарийн дагуу үүсэх зах зээлийн нэмэлт багтаамж 47.3 тэрбум төгрөг. 2-р сценарийн дагуу үүсэх зах зээлийн нэмэлт багтаамж 49.6 тэрбум төгрөг.

Нэмж шаардагдах тэжээлийн үнэлгээ сүү, махны үхрийн фермүүдэд 25-28 тэрбум төгрөг, гахайн фермүүдэд 8.1-8.5 тэрбум төгрөг, тахианы фермүүдэд 14 тэрбум орчим төгрөг байна.

Эрчимжсэн МАА-н тэжээлийн хэрэглээ нэмэгдэх потенциал

| Тэжээлийн төрөл | 1-р сценариар, тонн | 2-р сценариар, тонн |
|-------------------------------|---------------------|---------------------|
| Бүдүүн ба шүүст тэжээл | | |
| Өвс | 8,163 | -601 |
| Сүрэл | 3,464 | 3,464 |
| Ногоон тэжээл | 13,666 | 29,032 |
| Дарш | 852 | 7,933 |
| Хаягдал төмс, хүнсний ногоо | 1,617 | 1,617 |
| Бүдүүн ба шүүст нийт | 27,763 | 41,445 |
| Хүчит тэжээл | | |
| Үр тарианы хаягдал | 13,747 | 21,143 |
| Уурагт тэжээлийн ургамал | | 3,431 |
| Хивэг | 33,119 | 12,967 |
| Холимог хүчит тэжээл | 20,007 | 26,868 |
| Хүчит тэжээл нийт | 66,874 | 64,409 |
| Нийт | 94,637 | 105,854 |

Эрчимжсэн МАА-н тэжээлийн хэрэглээ нэмэгдэх потенциал

| Тэжээлийн төрөл | 1-р сценариар, сая төгрөг | 2-р сценариар, сая төгрөг |
|-------------------------------|---------------------------|---------------------------|
| Бүдүүн ба шүүст тэжээл | | |
| Өвс | 1,633 | -120 |
| Сүрэл | 346 | 346 |
| Ногоон тэжээл | 3,417 | 7,258 |
| Дарш | 213 | 1,983 |
| Хаягдал төмс, хүнсний ногоо | 323 | 323 |
| Бүдүүн ба шүүст нийт | 5,932 | 9,791 |
| Хүчит тэжээл | | |
| Үр тарианы хаягдал | 4,812 | 7,400 |
| Уурагт тэжээлийн ургамал | | 1,811 |
| Хивэг | 18,216 | 7,132 |
| Холимог хүчит тэжээл | 18,299 | 23,500 |
| Хүчит тэжээл нийт | 41,326 | 39,842 |
| Нийт | 47,258 | 49,633 |

Бэлчээрийн МАА-н тэжээлийн хэрэглээ нэмэгдэх потенциал

- Малчдын тэжээлийн хэрэглээний өнөөгийн төвшинд малын тоо тогтмол өсөж, малын хорогдол 1-3 хувьтай байгаа нөхцөлд малчид нэг малд ногдох тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх магадлал бага.
- Гэвч цаашид малын тоо жилд 10 орчим хувиар өсөх хандлагатай учраас малын тооны өсөлтийг дагаж нэмэлт тэжээлийн хэрэгцээ бий болох бөгөөд бидний тооцоолсоноор 2020 он хүртэл малчдын өвсний хэрэглээ 20%-иар, ногоон тэжээлийн хэрэглээ 10-15 хувиар, хивэгний хэрэглээ 15-20-иар өсөх боломжтой.
- Үүнийг бодит хэмжээнд шилжүүлж тооцвол бэлчээрийн мал аж ахуйд 2020 он хүртэл жил бүр 100 мянга хүртэл тонн өвс, 1-2.5 мянган тонн хивэг, 300-600 тонн ногоон тэжээл шаардагдана.
- Мөнгөн дүнд шилжүүлбэл малчдын тэжээлийн хэрэглээ зөвхөн малын тооны өсөлтөөс шалтгаалан жилд 7-14 тэрбум төгрөгөөр нэмэгдэх боломжтой.

6-р бүлэг.
Шүүн хэлэлцэхүй
(бүлгийн товч дүгнэлт)

Дотоодын тэжээл үйлдвэрлэлийн боломжууд

- Хэдийгээр бэлчээрийн МАА-д тэжээлийн хэрэглээ нэмэгдэх хандлагатай боловч дотоодын тэжээл үйлдвэрлэлийн зах зээлийн гол боломж нь эрчимжсэн МАА-н тэжээлийн хэрэгцээ юм.
- Гэвч тэжээлийн хэрэгцээг бодит хэрэглээ болгохын тулд фермерүүд малын тэжээллэгийн талаар зохих мэдлэг, арга барил эзэмшиж, малаа хангалттай хэмжээн, зөв тэжээж сурах шаардлагатай.
- Түүнчлэн төрөөс дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого баримталж, тодорхой ажлуудыг 2020 хүртэл гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Үүнд эрчимжсэн МАА-г дэмжих чиглэлээр хийгдэх ажлуудыг мөн багтааж ойлговол зохино. Учир нь эрчимжсэн МАА-н фермүүд хөгжих хэрээр тэжээлийн зах зээл тэлэх болно.
- Тэжээлийн ургамлын тариалангийн хувьд 1-рт зөвхөн импортыг орлох төвшинд 14.5 тэрбум төгрөг, 2-рт эрчимжсэн МАА-н фермүүдийн тэжээлийн хэрэглээ одоогийн бүтцээрээ хангалттай хэмжээнд хүрэх төвшинд 17 тэрбум төгрөг, 3-рт фермүүдийн тэжээлийн хэрэглээ хэмжээ, бүтцийн хувьд сайжрах төвшинд 27 тэрбум төгрөгийн зах зээлийн боломж байна.

Дотоодын тэжээл үйлдвэрлэлд тулгарч буй гол бэрхшээлүүд

- Бүдүүн ба шүүст тэжээлийн дотоодын нийлүүлэлтэд тулгарч буй гол бэрхшээл нь байгалийн хадлан бэлтгэл бэлчээрийн доройтлыг ихэсгэх эрсдэл үүсгэж буй байдал юм. Цаашид өвсний хэрэгцээ нэмэгдэх нь тодорхой, харин энэ хэрэгцээг байгалийн хадлангаас хадах боломж Монгол оронд байгаа эсэх нь эргэлзээтэй.
- Сүрлийг малын тэжээлд ашиглаж буй нь мөн хөрс хамгаалах, тариалангийн талбайн сүрлэн хучлагыг дэмжих төрийн бодлоготой зөрчилдөж байна.
- Ногоон тэжээл, даршны хэрэглээ хангалтгүй байгаа нь юун түрүүнд малчид, фермерүүд хэрэглэж сураагүйтэй холбоотой. Борлуулалт нь эрсдэлтэй учраас тариаланчдад ногоон тэжээл, даршны ургамал тариалахад сонирхол бага байна. Эрчимжсэн МАА-н фермүүдийн хувьд тариалангийн газар, тоног төхөөрөмж дутагдалтай.
- Малчдад байгалийн өвсөөр дарш бэлтгэхийг сургаж хэвшүүлэх санаачлагыг зарим төслүүд хэрэгжүүлж ирсэн боловч энэ арга нь үзвэл дотоодын тэжээл үйлдвэрлэлд нөлөөлөл бага. Учир нь энэ нь нэмэлт биомасс бий болгох бус, нэгэнт талхагдаад буй бэлчээрийг л ашиглах өөр нэгэн арга юм.

Дотоодын тэжээл үйлдвэрлэлд тулгарч буй гол бэрхшээлүүд

- Хүчит тэжээлийн дотоодын нийлүүлэлтэд тулгарч буй гол бэрхшээл нь малчид, фермерүүдийн хангалтгүй хэрэглээ. Үйлдвэрлэгчид эрэлтийн хэмжээнд тохируулан нийлүүлж буй бөгөөд энэ нь тэдний үйлдвэрлэлийн хүчин чадлын дөнгөж 38%-тай тэнцэж байна. Нийт хэрэгцээ 150-160 мянган тонн боловч нийт хэрэглээ 2016 оны байдлаар 100 мянган тонн байна.
- Зах зээлийн боломжит нэмэлт багтаамж 40-41 тэрбум төгрөг боловч энэ боломжийг бодит байдал болгон хувиргахын тулд тэжээлийн хэрэглээ нэмэгдэх шаардлагатай.
- Хүчит тэжээлийн хэрэглээ бага байгаа гол шалтгаанууд нь:
 - Малын ашиг шим бага учир тэжээлийн зардлаа нөхөх боломж бага
 - Хүчит тэжээлийн үнэ өндөр
 - Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ бага, дээр нь малын ашиг шим бага тул малчид, фермерүүд орлого багатай,
 - Тэжээл, тэжээллэгийн талаар зохих мэдлэг, зохистой арга барил эзэмшээгүй.

Дотоодын тэжээл үйлдвэрлэлд тулгарч буй гол бэрхшээлүүд

- Судалгааны үр дүнгээс үзэхэд дээрх шалтгаануудын зарим нь үнэн хэрэгтээ шалтаг болохоос бодит шалтгаан бус. Тухайлбал малчид орлого багатай учир хүчит тэжээл авч чадахгүй байгаа гэх боловч үнэн хэрэгтээ 500-аас дээш малтай малчдын гар дээр жил бүр 500-600 тэрбум төгрөгийн орлого зарлагаас нь илүү гарч үлддэг. Үүнийг тэжээлд бус, хашаа байшин худалдан авах, шинэ машин авах гэх мэт өөр зүйлд зарцуулдаг.
- Малын ашиг шим муу байгаа нь мал үржлийн ажил үйлчилгээ орон нутагт хангалтгүй байгаатай, мөн малчдын санаачлага сул байгаатай холбоотой.
- Эрчимжсэн МАА-н фермүүдийн хувьд өрхийн фермүүд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг төрөөс нилээд үзүүлж ирсэн. Гэвч тухайн дэмжлэгийг үр дүнтэй зарцуулж чадаж буй эсэх нь эргэлзээтэй.
- Малын тэжээллэгийн сайжруулах асуудал нь зөвхөн хэмжээг нь нэмэх тухай биш, тэжээлийг зохистой хэмжээ, зохистой жор найрлагаар бэлтгэж ашиглах тухай юм. Өнөөгийн байдлаар сүү, махны үхрийн фермийн аж ахуйгаар жишээ авч үзвэл өрхийн фермүүд ихэвчлэн бүдүүн тэжээлд өвс, хүчит тэжээлд хивэг хэрэглэж буй нь гүзээнд азотын сөрөг баланс үүсгэж, тэжээлийн шингэцийг бууруулж, үндсэндээ тэжээлд зарцуулж буй мөнгөнийх нь зарим хэсгийг салхинд хийсгэж буй явдал юм. Фермерүүдийн мэдлэг мөнгөнөөс дутахгүй чухал болохыг фермерүүд өөрсдөө ч, мөн төрөөс ч анхаарч үзэхгүй байна.

7-р бүлэг.

Бодлогын зөвлөмж

1. Өвс, сүрлийн хэрэглээг хязгаарлаж, ногоон тэжээл, даршны хэрэглээг дэмжих

Үндэслэл:

- Хадлан бэлтгэлийг цаашид нэмэгдүүлэх нь бэлчээрийн доройтлыг улам ихэсгэнэ
- Сүрлийг тэжээлд ашиглахаас илүүтэй тариалангийн газрын хучлагад ашиглах, өөрөөр хэлбэл талбайд нь үлдээх шаардлагатай
- Сүү, махны үхрийн тэжээлд өвс их хэмжээгээр ашиглах нь түүнчлэн гүзээний азотын сөрөг баланс үүсгэж, тэжээлийн шингэцийг бууруулж байна.

Зөвлөмж:

- Аймаг, сумдын аюулгүйн нөөцийг өвсөөр бус, ногоон тэжээлээр бүрдүүлэх,
- Сумдад төр-хувийн хэвшлийн хамтарсан ААН-үүдийг байгуулж, ногоон тэжээл бэлтгэх санаачлагыг дэмжих. Бэлтгэсэн ногоон тэжээлийн зохих хувийг аймаг, сумын нөөцөд татаж авах.
- Малчид, фермерүүдэд хадлангийн тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцлөөр олгох ажлыг зогсоох. Үүний оронд сумдын ЗДТГ, малчдын хоршоо, эрчимжсэн МАА-н фермүүд, дээр санал болгосон ААН-үүдэд ногоон тэжээлийн үр, тариалангийн тоног төхөөрөмж олгох.
- Эрчимжсэн МАА-н фермүүдэд тариалангийн газар, тоног төхөөрөмж, тэжээлийн таримлын үр хөнгөлөлттэй нөхцлөөр олгох.

2. Тэжээлийн ургамлын тариалалтыг урамшуулах

Үндэслэл:

- Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд юуны өмнө түүхий эд буюу биомасс нэмж үйлдвэрлэх шаардлагатай.
- Тариаланчдад бэлэн байгаа тариалангийн газар, тоног төхөөрөмж, тариалан эрхлэх ноу-хауг тэжээлийн ургамлын тариаланг, ялангуяа буудайн сэлгээнд тэжээлийн ургамал тариалахыг нэмэгдүүлэхэд ашиглах зорилгоор урамшууллын механизм бий болгох нь зүйтэй.

Зөвлөмж:

- ТЭДС-аас тариаланчдад бордоо, ургамал хамгааллын бодис олгохдоо тэжээлийн ургамал тариалж буй тариаланчдад илүү хөнгөлөлт, давуу тал эдлүүлэх,
- Буудайн урамшууллын хэмжээг сэлгээний бүтцээс хамааруулан ялгавартай олгох, сэлгээнд тэжээлийн ургамал тариалж буй тариаланчдад бусдаас илүү урамшуулал олгох.

3. Тэжээлийн ургамлын үнэ цэнийн сүлжээ бий болгох

Үндэслэл:

- Тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх гол нөхцөл нь тэжээлийн таримлууд зардлаа нөхөөд ашиг олох боломжтой үнээр борлогдох боломжтой байх нөхцөл юм.
- Иймд тэжээлийн таримлын борлуулалтын олон суваг бүхий үнэ цэнийн сүлжээг бий болгох шаардлагатай.

Зөвлөмж:

- Хаягдлыг нь малын тэжээлд ашиглах боломжтой рапс, шар буурцаг, гич зэрэг тэжээлийн таримлуудыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд бодлогын дэмжлэг үзүүлэх,
- Эдгээр ургамлуудыг экспортлох тохиолдолд хаягдлыг нь эргээд малын тэжээлийн зориулалтаар хөнгөлөлттэй үнээр импортлох шаардлага тавих, холбогдох журам нэвтрүүлэх,
- Өөрөө тэжээл бэлтгэдэггүй эрчимжсэн мал аж ахуйн фермүүдэд хөнгөлөлттэй зээл олгохдоо зээлийн тодорхой хувийг (жишээ нь 5%) дотоодын тариаланчдаас тэжээлийн ургамал худалдан авахад зарцуулах шаардлага тавих. Улмаар тэжээлийн ургамлын нийлүүлэлтийг ТЭДС-аас нэгтгэн төлөвлөж, тариаланчдад захиалж бэлтгүүлэх.
- Дээр санал болгосон сумын төвшний тэжээл бэлтгэлийн ААН-үүдийг байгуулах боломжгүй бол тариаланчдын бэлтгэсэн ногоон тэжээлийг аймаг, сумдын аюулгүйн нөөцөд татан авах.

4. Тэжээлийн үйлдвэрийн шинэ хүчин чадал бий болгохоос өмнө одоо байгаа үйлдвэрлэгчдээ ДЭМЖИХ

Үндэслэл:

- Одоо ажиллаж буй тэжээлийн үйлдвэрүүд хүчин чадлынхаа дөнгөж 38%-ийг ашиглаж байна.
- ХХААХҮЯ-нд бүртгэгдсэн бага оврын тэжээл үйлдвэрлэлийн 53 нэгжийн дөнгөж 23 нь ажиллаж байна.
- Иймд шинээр тэжээл үйлдвэр байгуулах, мөн малчид фермерүүдэд бага оврын тэжээл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж олгох шаардлагагүй.

Зөвлөмж:

- Тэжээлийн 4 шинэ үйлдвэр байгуулах ажлыг одоо ажиллаж буй тэжээлийн үйлдвэрүүд хүчин чадлынхаа ядаж 50%-ийг ашигладаг болох хүртэл хойшлуулах,
- Малчид, фермерүүдэд бага оврын тэжээл бэлтгэлийн тоног төхөөрөмж олгох ажлыг зогсоох,
- Одоо ажиллаж буй тэжээл үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл, татварын дэмжлэг үзүүлэх.
- Тэжээл үйлдвэрлэгчдэд зайлшгүй шаардлагатай түүхий эдээ импортоор авахад нь татварын хөнгөлөлт үзүүлэх.

5. ХАА-н зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээг бодитоор бий болгох

Үндэслэл:

- Тэжээл үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримталж буй бодлогод хайхрахгүй буй нэг чухал асуудал бол малчид, фермерүүдийн малын тэжээллэгийн талаар мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, улмаар хэрэглээг нь нэмэгдүүлэх асуудал юм.
- Одоогийн ЗГ-ын мөрийн хөтөлбөрт “Хөдөө аж ахуйн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний тухай” хууль батлах зорилт багтсан боловч энэ хууль батлагдсан тохиолдолд 2020 оноос мөрдөгдөж эхэлнэ. Үүнээс өмнө энэ чиглэлээр тодорхой ажил төлөвлөөгүй байна.

Зөвлөмж:

- Сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдийг малын тэжээл, тэжээллэгийн чиглэлээр сургаж, малчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх чадвартай болгох, МЭҮТ-уудыг малын тэжээл, тэжээллэгийн сургалт, мэдээллийн материалаар хангах, малчдад аяны богц аялуулж малын тэжээлийн талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрийн тэжээлийг орон даяар сурталчлах,
- Аймгуудын ХХААГ-уудад хуучин ажиллаж байсан Экстейншиний төвүүдийг сэргээн байгуулах, төв бүрийг үзүүлэх сургалтын талбай, сургалтын өрөө, тэжээлийн тариалангийн бага оврын тоног төхөөрөмж, үйл ажиллагааны төсвөөр хангах,
- ХХААХҮЯ-нд нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан мэргэжилтний орон тоо бий болгох
- Эрчимжсэн мал аж ахуйн зөвлөхүүдийг сертификатжуулах, сертификаттай зөвлөхүүдэд нэвтрүүлэх үйлчилгээний ажил даалгаж гүйцэтгүүлэх.

6. Тэжээл үйлдвэрлэлийн институцийн орчныг сайжруулах

Үндэслэл:

- Тэжээл үйлдвэрлэлийн асуудал нь мал аж ахуй, газар тариалангийн салбарын аль алинд хамааралтай нь нэг талаар давуу тал боловч нөгөө талаар тухайн салбарын бусад тэргүүлэх чиглэлүүдэд дарагдаж үл хайхрагдах эрсдэлтэй.
- Түүнчлэн тэжээлийн нийлүүлэлт, хэрэглээний талаар статистик мэдээ хангалтгүй, Тэжээлийн Нэгжийн шкал хэмээх одоогийн хэрэгцээнд нийцэхгүй шкалыг бодлогын баримт бичгүүдэд ашигласаар байна.

Зөвлөмж:

- Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлогын хүрээнд “Малын тэжээл” дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
- Тэжээл, тэжээллэгийн эрдэм шинжилгээ, инновацийн ажил, старт-ап компаниудад бодлогын дэмжлэг үзүүлэх
- Тэжээл тариалж буй буюу тариаланчдаас тэжээл тогтмол худалдан авдаг малчид, фермерүүдийн хоршоодод бодлогын дэмжлэг үзүүлэх
- Тэжээл үйлдвэрлэлийн статистик мэдээний чанарыг сайжруулах
- Тэжээлийн нэгжийн шкалыг хэрэглэхээ болих, энерги, уургийн нэгж ашиглаж хэвших.

**Анхаарал тавьсанд
баярлалаа!**